

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/15

Арвайхээр

Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн үед ажиллах мэргэжлийн баг томилох тухай

Монгол улсын эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Дархлаажуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1.6 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2012 оны "Дархлаажуулалтын тухай" 217, Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны "Журамд өөрчлөлт оруулах тухай" А/278, Эрүүл мэндийн сайдын 2017 оны "Дархлаажуулалтын хороо байгуулах тухай" А/315, А/316 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн үед ажиллах мэргэжлийн багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Дархлаажуулалтын дараах урвал хүндрэл гарсан үед багийн гишүүдийг удирдлага, мэргэжил арга зүйгээр ханган, авах арга хэмжээг шуурхай зохион байгуулахыг багийн ахлагч, дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн (М.Золзаяа) -д үүрэг болгосугай.


3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

ЭМГ-ын даргын 2021 оны 08 сарын 03  
– ны өдрийн 4/6 дугаар тушаалийн  
нэгдүгээр хавсралт



**ДАРХЛААЖУУЛАЛТЫН ДАРААХ УРВАЛ, ХҮНДРЭЛИЙН  
ҮЕД АЖИЛЛАХ МЭРГЭЖЛИЙН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**


Багийн ахлагч: М.Золзаяа, ЭМГ-ын дархлаажуулалтын асуудал хариуцсан  
мэргэжилтэн

Гишүүд:

1. Б.Ариунзаяат, ЭМГ-ын хүүхдийн асуудал хариуцсан  
мэргэжилтэн
2. Д.Энхбаатар, БОЭТ-ийн мэдрэлийн эмч
3. Ж.Нарантуяа, БОЭТ-ийн чанарын менежер
4. Н.Чулуунзаяа, БОЭТ-ийн мэс заслын эмч
5. Х.Мөнгөнтуяа, БОЭТ-ийн нян судлалын лабораторийн эмч
6. Д.Дуламсүрэн, БОЭТ-ийн иммунологийн лабораторийн эмч

Шаардлагатай тохиолдолд зарим нарийн мэргэжлийн эмч нарын татан  
оролцуулна.

ЭМГ-ын даргын 2021 оны 06 сарын  
03-ны өдрийн 1/5 дугаар тушаалийн  
хоёрдугаар хавсралт



## МЭРГЭЖЛИЙН БАГИЙН АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Дархлаажуулалтын дараах урвал хүндэрлийн шалтгаан хамаарлыг тогтоох мэргэжлийн баг нь сэргийлэх тарилга буюу дархлаажуулалтын улмаас хүний эрүүл мэндэд учирсан тогтвортой эсхүл ноцтой хямралзд хийсэн шалтгаан хамаарлыг үнэлэн, санал, дүгнэлт зөвлөмж гаргах үндсэн үүрэг бүхий орон тооны бус баг юм

### Хоёр. Мэргэжлийн багийн үйл ажиллагааны чиглэл

- 2.1. Дархлаажуулалтын дараах урвал хүндрэл /ДДУХ/-ийн тохиолдлын мэдээ авмагц мэргэжлийн баг ажиллана.
- 2.2. ДДУХ-ийн багц болон ноцтой тохиолдлуудад судалгаа хийж, шалтгаан хамаарлыг тогтоон санал, дүгнэлт, зөвлөмж гаргах
- 2.3. Мэргэжлийн баг нь ДДУХ-ийн тохиолдлын шалтгааныг тогтоох зорилгоор дархлаажуулалттай холбоотой бүх үйл ажиллагааг хянан нарийвчлан судалгааг ажлын 3 хоногт багтаан хийж, эхний дүгнэлтийг гарган, аймгийн мэргэжлийн хяналтын газрын эмчилгээний чанарын хяналтын байцаагчид хүргүүлж, ДДУХ-ийн сэжигтэй тохиолдлыг магадлан тогтооно
- 2.4. ДДУХ-ийн сэжигтэй тохиолдолд үзүүлж буй эмнэлгийн тусламж үйлчилгээг хянаж, шардлагатай тохиолдолд дараагийн шатны эмнэлэгт шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.
- 2.5. Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн багийн гишүүдийг оролцуулан шалтгаан хамаарлыг үнэлэх багийг дахин томилж, үнэлгээнд мэргэжил арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх
- 2.6. ДДУХ-ийн тандалтын явцтай танилцан мэргэжлийн арга зүйн зөвлөмж өгөх